

## **ТАНИЛЦУУЛГА**

### **АСЕАН-ы бүсийн чуулга тухай буюу**

#### **АРФ-ын тухай**

##### **1. АРФ-ын зорилт**

АРФ-ын гол зорилт нь бүс нутгийн энх амгалан байдал, хөгжил цэцэглэлийг бэхжүүлэх явдал мөн. Үүний тулд АРФ:

-Эдийн засгийн хөгжлийн хурдацыг дагалдан бүс нутаг дахь хүчний харилцаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан, тэр нь даамжран улмаар мөргөлдөөнд хүргэж болох талтайг АРФ анхаарч энхийг сахин хамгаалах үүднээс шилжилтийг туйлын хянуур, болгоомжтой хийх,

-Бүс нутгийн улс орнуудын аюулгүй байдлын асуудалд хандах хандлага ихээхэн ялгаатайг АРФ харгалзан үзэж, энэ асуудлаар баримтлах чиг бодлогыг зөвшилцлийн үндсэн дээр тохиролцох,

-Бүс нутгийн орнуудын хооронд газар нутгийн болон бусад маргаантай асуудлууд цөөнгүй байдаг. Тэдгээр нь бүс нутгийн энх тайван аюулгүй байдалд аюул учруулж болох талтай. Иймд болзошгүй аюулыг таслан зогсоох асуудлыг АРФ аажмаар, тодорхой цаг хугацаанд шийдвэрлэх шаардлагатай гэж үздэг.

##### **2. Үүсгэн байгуулагдсан түүх**

АСЕАН-ы бүсийн чуулга уулзалт /АРФ/-ын анхны хурал 1994 онд Бангкок хотноо зохион байгуулагдаж, аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг анхны бөгөөд одоогоор цорын ганц албан ёсны олон талт үйл явц Ази Номхон далай /АНД/-н бүс нутагт бий болсон.

1990-ээд оны эхэн хүртэл АНД-н аюулгүй байдлын бүтцийг гагцхүү хоёр талт цэрэг улс төрийн түншлэлийн харилцаанууд /АНУ-Өмнөд Солонгос, ЗХУ-Вьетнам, ЗХУ-Монгол гэх мэт/ бүрдүүлдэг байжээ. 1 АНД-н бүс нутагт Европ тивтэй адил олон талт аюулгүй байдлын институцууг бүрэлдээгүйн гол шалтгаан нь, нэгд, бүс нутаг дахь гол орнуудын харилцааны онцлог/ Жишээлбэл, Умард Солонгос Японы хооронд дипломт харилцааг гагцхүү 1960-аад онд эцсээр тогтоосон байна/, хоёрт, том гүрнүүдийн сонирхол/ том гүрнүүдийн хувьд өөрийн түншүүдэд шахалт нөлөө үзүүлэхэд хялбар/, гуравт, олон талт дипломатийн туршлага, соёл бүрэлдээгүй явдал байжээ. Харин хүйтэн дайн төгсгөл болж, ЗХУ задарч, БНХАУ-ын хүч нөлөө эрс нэмэгдэж, АНУ Филиппинээс өөрийн цэргийн баазаа гаргаж авснаар олон талт үйл явцууд бүс нутгийн орнуудын удирдагчдын анхаарлыг татах болов.

Японы Гадаад хэргийн сайд асан Таро Накаяма АРФ-ыг байгуулах тухай

саналыг анх 1991 онд АСЕАН-ы сайд нарын уулзалтын дараах уулзалтын /ПМС/ үеэр дэвшүүлсэн боловч уг саналыг АСЕАН-ы зарим орон, Бушийн засаг захиргаа болгоомжлон хүлээн авав. Харин 1993 оноос Клинтонь засаг захиргаа олон тал үйл явцад нааштай хандахаа мэдэгдсэн бөгөөд улмаар 1993 онд АСЕАН-аас АРФ-ыг байгуулах шийдвэр гаргасан.

**Гол санаа:** АРФ нь аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг АНД-ын бүс нутаг дахь цорын ганц албан ёсны олон талт үйл явц. Энэ нь гол төлөв хоёр талт харилцаанаас бүрдэж байсан бүс нутгийн аюулгүй байдлын бүтцэд зарчмын шинэ өөрчлөлт гарч буй шинж тэмдэг мөн.

### **3. АРФ-ын бүтэц**

а) Нэгдүгээр сувгийн уулзалтууд /трак 1/

АРФ-ын хүрээнд явагдаж буй Засгийн газар хоорондын албан ёсны уулзалтуудыг нэгдүгээр сувгийн арга хэмжээ гэж тодорхойлдог.

АРФ-ын гол арга хэмжээ нь жил бүрийн 7 дугаар сард явагддаг АРФ-ын чуулга уулзалт юм. Одоогоор:

Анхны чуулга уулзалт 1994 оны 7 дугаар сард Бангкок,т,

Хоёрдугаарх нь 1995 оны 6 дугаар сард Брунейд

Гуравдугаарх нь 1996 оны 7 дугаар сард,

Дөрөвдүгээрх нь Малайзид 1997 оны 7 дугаар сард,

Тавдугаарх нь Филиппинд энэ оны 7 дугаар сард сард тус тус болжээ.

Чуулга уулзалт нэг хоног үргэлжилдэг. АРФ-ын чуулга уулзалтад оролцогч орнуудын гадаад хэргийн сайд нар гадаад харилцаа болон батлан хамгаалах яамдын ахлах албан тушаалтнуудын хамт оролцдог.

Чуулга уулзалтын дараа даргын мэдэгдлийг гаргадаг. Энэхүү мэдэгдэлд чуулга уулзалтын үеэр хэлэлцсэн асуудлууд, хийж гүйцэтгэсэн ажил, цаашид хийх зүйлүүдийг тодорхойлдог.

Чуулга уулзалт нь АРФ-ын бусад бүх арга хэмжээний адил гагцхүү англи хэлээр орчуулагагүй явагддаг.

АРФ-ын сайд нарын хэмжээний чуулга уулзалтын өмнө жил бүрийн 5 дугаар сард Ахлах албан тушаалтны уулзалтыг зохион байгуулдаг. Энэ уулзалтад оролцогч орнуудын Гадаад харилцааны яамдын ахлах албан тушаалтан нар оролцдог. Уулзалтын үеэр сайд нарын хэмжээний чуулга уулзалтаас гаргах даргын мэдэгдлийг урьдчилан хэлэлцэж тохирдог.

Үүнээс гадна АРФ-ын хүрээнд:

-Итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээний чуулган хоорондын уулзалт,

-Гамшгийн уршгийг арилгах асуудлаархи чуулган хоорондын уулзалт,

-Энхийг сахиулах асуудлаархи чуулган хоорондын уулзалт жил бүр зохиогддог.

Эдгээрт оролцогч орнуудын гадаад хэрэг, батлан хамгаалах яам, бусад холбогдох газруудын албан тушаалтнууд оролцдог.

Мөн Цэргийн сургуулийн захирал нарын уулзалт, ахлах албан

тушаалтны семинар, халуун бүсийн анагаах ухааны асуудлаархи бага хурал, батлан хамгаалахын цагаан номыг боловсруулах асуудлаархи семинар зэрэг арга хэмжээ 1998-99 явагдана.

#### **б) Хоёрдугаар сувгийн уулзалтууд /трак 2/**

АРФ-ын хүрээнд зохион байгуулагдаж буй албан бус уулзалтуудыг хоёрдугаар сувгийн арга хэмжээ гэж тодорхойлдог.

Иж бүрэн аюулгүй байдал, хамтын ажиллагааны асуудлаархи бага хурал, гамшгийг арилгах нэгдсэн зарчмын асуудлаархи бага хурал 1998-99 онд явагдана.

#### **4. Гишүүнчлэл**

Өдгөө АРФ 22 оролцогчтой: АСЕАН-ы гишүүн /Бруней, Вьетнам, Лаос, Малайз, Мьянма, Индонез, Сингапур, Тайланд, Филиппин/, АНУ, Австрал, БНХАУ, Камбож, Канад, Монгол, Өмнөд Солонгос, Энэтхэг, ОХУ, Папуа Шинэ Гвиней, Шинэ Зеланд, Япон, Европын холбоо.

1998 оны 7 дугаар сарын 26-ны өдөр болсон АРФ-ын 5 дугаар чуулга уулзалтаас Монголыг (шинэ оролцогч улсаар) элсүүлэх тухай шийдвэр гаргасан.

АРФ-д шинээр улс орон элсүүлэхдээ дараах зарчмыг баримтлана гэж талууд тохиоролцсон ажээ.

Шинээр оролцогч орон нь АРФ-ын үндсэн зорилтуудыг бүрэн хүлээн зөвшөөрч, тэдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө бусад оролцогчидтой хамтран ажиллана.

АРФ-аас урьд өмнө гаргасан шийдвэр мэдэгдлүүдийг хүлээн зөвшөөрч, даган биелүүлэх үүрэгтэй.

Тэрээр АНД-н бүс нутгийн аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлж чадахуйц орон байх ёстой бөгөөд газар зүйн хувьд Зүүн Ази /Зүүн Өмнөд болон Зүүн Хойд Ази/, Океанид байршилтай байна гэжээ.

Өдгөө Ази Номхон далайн бүс нутгийн 11 улс орон АРФ-д нэгдэх хүсэлтээ илэрхийлээд байгаа.

Гол санаа: Зүүн Өмнөд Азийн орнууд зонхилсон үйл явц. Зүүн Хойд Азийн орнуудын тоо нэмэгдэж байгаа, мөн аюулгүй байдлын гол асуудлууд Зүүн Хойд Азийн орнуудтай холбоотой.

#### **5. АРФ-ЫН ХӨГЖИЛ**

Зарим нэг асуудлаар гагцхүү санал солилцож, тодорхой шийдвэр гаргадаггүй чуулга уулзалт хэлбэрээр АРФ 1994 онд анх үйл ажиллагаагаа эхэлжээ. Харин одоо итгэлцлийг бэхжүүлэх тодорхой арга хэмжээг хэлэлцэн тохирдог, дүгнэлт өгдөг чуулга уулзалт болтлоо хөгжиж, урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагааны механизмыг хөгжүүлэх талаар зарим нэг зүйлийг хийж эхлээд байна.

Бангкок хотноо болсон АРФ-ын анхны чуулга уулзалт нь гол төлөв процесс-прогресс гэдэг утгаараа ач холбогдолтой байсан. Хүйтэн дайны үед хоорондоо дайсагналцаж байсан, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг олон талт форумын хүрээнд хэлэлцэж байгаагүй талууд цугларсан гэдгээрээ чухал байжээ.

Харин Брунейд болсон хоёрдугаар уулзалтаас зарим нэг тодорхой зүйлүүдийг хэрэгжүүлэхээр санал болгосон. Энэхүү уулзалтас АРФ-ын үндсэн зорилт, зарчим, хөгжлийн төлвийг тусгасан "Үзэл баримтлал"-ын баримт бичгийг баталсан. Мөн АРФ-ын хүрээнд чуулган хоорондын 3 ажлын бүлгийг /итгэлцлийг бэхжүүлэх, энхийг сахиулах, эрж аврах асуудлаар/ байгуулахаар шийдвэрлэсэн ажээ. Энэ нь АРФ-ын хүрээнд тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх эхлэлийг тавьсан.

1995 оноос хойшхи гурван жилийн туршид АРФ итгэлцлийг бэхжүүлэх талаар дорвитой зүйл хийж, АРФ-ын үйл ажиллагаанд Хятадыг хамруулж, өргөн төлөөлөлтэй үйл явц болсон.

**Гол санаа:** Итгэлцлийг бэхжүүлэх асуудлаар тодорхой зүйлүүдийг хэлэлцэн тохиролцож, хэрэгжүүлдэг өргөн төлөөлөлтэй үйл явц болсон. Цаашид урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагааны механизмыг хөгжүүлэх асуудалд улам их анхаарах төлөвтэй.

#### **6. Институционал хөгжлийн хурдац**

АРФ-ын өмнө тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд аажмаар хувьсган өөрчлөх /эволюци/ чиг баримтлах хэрэгтэй гэж үзсэн бөгөөд үүнийг гурван үе шаттай хэрэгжүүлэхээр тодорхойлжээ.

Үүнд:

I Үе шат: Итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

II Үе шат: Урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагааны механизмийг хөгжүүлэх

III Үе шат: Мөргөлдөөнийг зохицуулан шийдвэрлэх механизмийг хөгжүүлэх болно гэж уг "Үзэл баримтлал"-д дурджээ.

Одоогоор АРФ нь нэгдүгээр үе шатны итгэлцлийг бэхжүүлэх үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулж байна.

**Гадаад харилцааны яамны нэгдсэн бодлогын газраас бэлдэв.**